



**ХЭНТИЙ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ХЭРЛЭНБАЯН-УЛААН ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 05 өдөр

Дугаар А/14

Хэрлэнбаян-Улаан тосгон

Ёс зүйн дэд хороо байгуулах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 25 дугаар зүйлийн 25.1, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийн 10 дугаар зүйлийн 10.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2, 13.3, 13.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Төсөвт байгууллагуудын төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах зорилгоор “Хэрлэнбаян-Улаан тосгоны ёс зүйн дэд хороо”-г дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: С.Отгонбаяр – Захирагчийн ажлын албаны дарга

Нарийн бичиг: Б.Энхсаруул – Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүд: Н.Гэрэлтуяа – Бага эмч

Д.Солонго – Ерөнхий боловсролын сургуулийн захирал

П.Должин – Номын санч

2. Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хянах, ёс зүйн зөрчилтэй холбоотой иргэдийн өргөдөл, гомдлыг хэлэлцэх, сургалт, сурталчилгаа, зөвлөмж гаргах, шаардлагатай тохиолдолд хариуцлага тооцуулах саналыг гаргах ажлыг хийж гүйцэтгэхийг ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3. Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааг шударга, хараат бус, хуульд нийцүүлэн хэрэгжүүлэхийг ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүнд даалгасугай.

ЗАХИРАГЧ



Б.ЭНХЦЭЦЭГ